



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Нэрс батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 49 дугаар тогтоолоор батлагдсан цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын 6 дугаар зүйлийн 6.20 “а” дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 45 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх алба хаах хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг үндэслэн дараах нэр бүхий 8 иргэнийг дүйцүүлэх алба хаалгахаар хавсралт ёсоор баталсугай.

2. Дүйцүүлэх алба хаах иргэдэд мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, сургалт, ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хувцас хэрэгслийн зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж байхыг төсөв ерөнхийлөн захирагч дүүргийн Засаг дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 сарын
02-ны өдрийн 29 дүгээр тогтоолын хавсралт



Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн товч анкет

Д/Д	Овог нэр	Цэргийн үүрэгтний үнэмлэхний дугаар	Албан тушаал	Өргөдөл өгсөн эсэх	Гэрийн хаяг
1	Төмөрбаатар Билгүүн	0113008631	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.15	3-р хороо 3-42
2	Амарсанаа Цогтсайхан	0113002976	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.15	3-р хороо 43-54т
3	Түвшинжаргал Тэнүүн	0113008641	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.16	10-р хороо чин 9- 2696
4	Хөхий Мөнхзаяа	0113002714	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.16	19-р хороо яргайт богино 1-6 тоот
5	Мэндбаяр Даваажав	0113003853	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.16	8-р хороо дунд тасган 5-36тоот
6	Төрбат Бат-Эрдэнэ	0113007057	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.17	12-р хороо Б-1-86а тоот
7	Ганхуяг Эрдэнэ-Очир	0113008678	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.15	11-р хороо нуурын 21-555
8	Энхтайван Баттөмөр	0113002114	Дүйцүүлэх албан хаагч	2014.04.17	12-р хороо Булаг 18-895а



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

“МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ”-ООР

- | | |
|-------------------------|---|
| 1. Данзангийн Лхамсүрэн | Монголын “Саран ээж” нийгэмлэгийн гүйцэтгэх захирал |
|-------------------------|---|

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ”-ООР

- | | |
|--------------------------|--|
| 1. Бадамдашийн Цэцэгээ | “Хан Монгол” морьтны холбооны жүжигчин |
| 2. Гомбо-Очирын Тунгалаг | Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны өндөр настан |
| 3. Суръяагийн Оюунтогтох | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан |

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛ”-ООР

- | | |
|--------------------------|---|
| 1. Чогсомжавын Сарантуяа | Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн багш |
| 2. Сүхийн Тойвгоо | Нийслэлийн хэрэглэгдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал |

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАРИЛГАЧИН ЦОЛ”-ООР

- | | |
|-----------------------|---|
| 1. Цэрэнгийн Бямбажав | Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны өндөр настан |
|-----------------------|---|

“МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН ЦОЛ”-ООР

- | | |
|-------------------|---|
| 1. Баньдын Чутнай | Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн багш |
|-------------------|---|

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН ”-ГООР

- | | |
|---------------------------|---|
| 1. Дэндэвийн Янжин | Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны өндөр настан |
| 2. Дашцэрэнгийн Чулуунбат | Мон-Энержи Консалт ХХК-ийн зөвлөх инженер |
| 3. Жигмэдийн Ланданноров | Мон-Энержи консалт ХХК-ийн зөвлөх инженер |
| 4. Сэдхүүгийн Наранчимэг | Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбооны захирал |
| 5. Дуламын Сод | Мон-Энержи Консалт ХХК-ийн зөвлөх инженер |
| 6. Данаагийн Ганчимэг | Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн сувилагч |

“ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН ”-ГООР

- | | |
|-------------------|--|
| 1. Сандуйн Энэбиш | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан |
|-------------------|--|

“АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР

- | | |
|------------------------------|--|
| 1. Ганжуурын Цэрэннадмид | Төрийн банкны төлбөр тооцооны хэлтсийн банк хоорондын нягтлан бодогч |
| 2. Дамдинсүрэнгийн Сарантуяа | Төрийн банкны цайз тооцооны төвийн ахлах теллер |
| 3. Баярын Батаа | Төрийн банкны мөнгөний төвийн мэргэжилтэн |
| 4. Ямааранзын Чулуунбаатар | Төрийн банкны сансар тооцооны төвийн захирал |
| 5. Содоогийн Рэгзмаа | Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн багш |

6. Чойжилийн Алтанцэцэг	Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн багш
7. Гүржавын Пунцагдаш	Урт цагаан ХХК-ийн ерөнхий захирал
8. Цэвээний Хоролсүрэн	Санхүүч Аудит ХХК-ийн аудитор
9. Лувсандоржийн Дархицэрэн	Мөнх гандир ХХК-ийн эрүүл ахуйч эмч, захирал
10. Дамбын Загдсүрэн	Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн багш
11. Доржхандын Энхжаргал	Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн багш
12. Жанчивдоржийн Цэцгээ	Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн багш
13. Цэрэнгийн Цэнгэл	“Монгол шуудан” ТӨХК-ийн маркийн газрын зураач
14. Аюушийн Даариймаа	“Монгол шуудан” ТӨХК-ийн ахмад шууданч

“ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОН”-ГООР

1. Цэвээний Батсүмбэр	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн
-----------------------	---

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР

1. Батсүрэнгийн Баярчимэг	Төрийн банкны хяналт шалгалтын газрын захирал
2. Жоожийн Болормаа	Төрийн банкны бүтээгдэхүүн хөгжил хариуцсан дэд захирал
3. Баярмөнхийн Болормаа	Төрийн банкны хүний нөөцийн газрын сургалт хөгжлийн хэлтсийн захирал
4. Ласрангийн Батчимэг	Төрийн банкны бүртгэлийн газрын дотоодын данс, аж ахуйн тооцооны хэлтсийн ахлах нягтлан бодогч
5. Лханаагийн Чулуунцэцэг	Төрийн банкны Баянзүрх дүүрэг” салбарын ерөнхий нягтлан бодогч
6. Данзанжамцын Лхамсүрэн	Төрийн банкны “Баянгол дүүрэг” салбарын мэргэшсэн теллер
7. Жамбалын Энхцэцэг	Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн багш
8. Батхуягын Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн багш
9. Амгалангийн Эрдэнэцэцэг	Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн багш

- | | |
|-------------------------------|---|
| 10. Дашдэлэгийн Чимэдцэрэн | Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн багш |
| 11. Баасанжавын Сангажав | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан |
| 12. Даваасамбуугийн Оюунцэцэг | Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуулийн багш |
| 13. Шийтэвийн Долгорсүрэн | “Монгол шуудан” ТӨХК-ийн маркийн газрын гадаад харилцааны мэргэжилтэн |
| 14. Осорын Энхболд | “Монгол шуудан” ТӨХК-ийн маркийн газрын дугтуйны үйлдвэрийн мастер |
| 15. Дугарсүрэнгийн Оюунчимэг | “Монгол шуудан” ТӨХК-ийн маркийн газрын дэвтэрлэгч |
| 16. Бадамын Цэцэндаваа | “Монгол шуудан” ТӨХК-ийн төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга |

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 165 дугаар тогтоолоор баталсан “Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журам”-ыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурьдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнахаар шийдвэрлэсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 сарын
02-ны өдрийн 31 дугаар тогтоолын хавсралт



Шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1.	Д.Ганболд	Бараадийган ХХК-ний захирал	ЧН66030414
2.	Л.Энхтуяа	Хүүш хайрхан ХХК-ний менежер	МЮ63122064
3.	Д.Батбаяр	7-р хорооны хэсгийн ахлагч	ХЖ79112418

Төлөвлөсөн: Дотоод ажил хариуцсан
ажилтан

Ч.Энхчимэг



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн Цогтбаатар овогтой Заяасайхан нь 2 өнчин дүүгийн хамт амьдралын хүнд нөхцөлд амьдардаг бөгөөд амьдрал ахуйд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах зардал 1000000 (нэг сая) төгрөгийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (Ц.Алтанцацрал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

┌ Зуны түр худалдаанд дагаж мөрдөх ┐
└ журам батлах тухай ┘

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг 2014 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

4. Тогтоол гарсантай холбогдуулан Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2014 оны 05 дүгээр сарын
02-ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ЗУНЫ ТҮР ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар тогтоолын дагуу Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт зуны сүүдрэвчтэй түр худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үйл ажиллагаандаа хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас зохицуулалт хийж хяналт тавихад энэхүү журмыг баримтална.

1.2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл холбогдох хууль тогтоомж, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлнэ.

1.3. Хүнсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгж, иргэн нь бүтээгдэхүүний дээжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн дүгнэлт, сүү сүүн бүтээгдэхүүнд Мал эмнэлгийн үржлийн албанаас гарал үүслийн гэрчилгээг тус тус гаргуулсан байна.

1.4. Зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нь "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна.

1.5. Холбогдох эрх бүхий байгууллагын /МХХ/ мэдээллийн санд бүртгэгдсэн тухайн дүгнэлтийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтэстэй "Үйлчилгээ эрхлэх гэрээ" байгуулж зөвшөөрөл олгоно.

1.6. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч этгээд нь нийслэлийн соёл, иргэдийн эрх ашигт нийцсэн үйлчилгээг явуулж, дүүргийн бүтээн байгуулалт, тохижилтонд дорвитой хувь нэмэр оруулж, орон нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвхитэй оролцоно.

Хоёр. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг үүрэг.

2.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч этгээд нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, нийслэлийн нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан дүрэм, журам, нутгийн өөрөө удирдах болон төрийн

захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг чанд биелүүлж, хотын тохижилт, соёлжилтонд онцгой анхаарч ажиллана.

2.2. Үйлчилгээнд ажиллагсад нь зориулалтын ажлын түр байрыг /сүүдрэвч/ ижил өнгө, хэмжээтэйгээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоосон байршилд ажлын онцлогт нийцсэн хувцас хэрэглэж, энгэртээ тэмдэг зүүх бөгөөд шаардлагатай ажлын байранд эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан байна.

2.3. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч этгээд нь бүтээгдэхүүний чанарын баталгааг хангасан шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүн худалдаалах бөгөөд баталгаат жин хэмжүүр хэрэглэх, бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчдад зориулалтын сав баглаа боодолд хийж худалдаална.

2.4. Айраг худалдаалах гэр нь үндэсний ёс, дэг жаягт нийцсэн байх ба айргийг уламжлалт аргаар хөхүүрт боловсруулан хадгалж худалдаална.

2.5. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь орчин тойрондоо гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргахгүй ажиллах үүрэгтэй.

2.6. Хог хаягдал гаргасны төлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан тарифаар Засаг даргын Тамгын газрын дансанд төвлөрүүлсэн байна.

2.7. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас хариуцуулсан талбайг орчны бохирдолгүй, ил задгай хог хаягдал үүсгэхгүй цэвэр байлгах үүрэгтэй.

2.8. Хог хаягдал тээвэрлэлтийн хураамжийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан тарифийн дагуу тооцож төлнө.

Гурав. Тусгайлан хүлээх үүрэг

3.1. Сүүдрэвчтэй худалдаа /жимс, жимсгэнэ, төмс хүнсний ногоо, ус ундаа, квас, зайрмаг, айраг, зориулалтын төхөөрөмж бүхий түргэн хоолны цэг г.м / эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийн байршлыг баталгаажуулж, тохижилт, орчны болон үйлчилгээний эрүүл ахуйн шаардлагыг хангасан нөхцөлд зөвшөөрөл олгоно.

3.2. Хүнсний бараа бүтээгдэхүүнийг олон тоогоор багцалж бөөнөөр худалдан авч, жижиглэн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд бараа бүтээгдэхүүн, материалыг худалдан авагчдад нийлүүлэхдээ уг барааны аюулгүй байдал, чанар, баталгаажилтын шаардлага хангасан тухай Мэргэжлийн байгууллагаас олгосон дүгнэлтийг дагалдуулж өгнө.

3.3. Айраг худалдаалах үйлчилгээ эрхлэгч нь нийлүүлэгч эх үүсвэрийг тодорхой болгох ба бусад эх үүсвэрээс айраг нийлүүлэх тохиолдолд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, баталгаат байдлыг хангасан дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулсан байна.

3.4. Зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь 10.00-21.00 цагийн хооронд үйл ажиллагаа явуулна.

3.5. Хог хаягдлыг дүүргийн Засаг даргын Тамгын газартай гэрээгээр ажилладаг хог тээвэрлэгч байгууллагууд тогтоосон цагийн хуваарын дагуу тээвэрлэнэ.

Дөрөв. Хориглох зүйл

4.1. Үйлчилгээ эрхлэгч нь Засаг даргын Тамгын газраас тогтоосон үйлчилгээний чиглэлээс бусад үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

4.2. Хадгалах хугацаа дууссан, чанарын баталгаагүй бараа бүтээгдэхүүн худалдаалахыг хориглоно.

4.3. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил үйлчилгээний холбоотой худал мэдээллэл өгөхийг хориглоно. / ХЭХАХ-ийн 12.8/

4.4. Насан хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 107 тоот тушаал/

Тав. Хяналт тавих

5.1. Худалдаа, үйлчилгээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл” хяналт тавина.

5.2. Аж ахуйн нэгж, иргэн шалгалтаар очсон ажилтны бичиг баримт, удирдамжтай танилцаж ажлаа шалгуулах бөгөөд өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж хариу мэдэгдэнэ.

5.3. Худалдаа, үйлчилгээний талаарх мэдээллэл, гомдол саналын дагуу хяналт тавих байгууллагууд олон нийтийн хяналтыг зохион байгуулж шат шатандаа тухай бүр шийдвэрлэж байна.

Зургаа. Хүлээлгэх хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Холбогдох хууль тогтоомж, стандарт, энэхүү журмын заалтуудыг давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг бүрэн зогсоох арга хэмжээ авна.

6.3. Үйл ажиллагааг нь бүр мөсөн зогсоосон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн талаар хэвлэл, мэдээллээр сурталчлан сэрэмжлүүлнэ.

Боловсруулсан: Ч. Энхшарав
Хянасан: Р. Сэлэнгэ.
Хувь: 21.

20.14. он .05 сар .02 өдөр



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Шагналын загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Чингэлтэй дүүргийн нэрэмжит шагналын загварыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА




Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 сарын
02-ны өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Шагналын загврууд

Шилдэг аж ахуйн нэгж



Хөшөөний оройн мэлмийд гал, нар, сарыг бэлэгдэж, тэдгээрийг тулж
залгамжлах "Есөн хөлт цагаан туг"-аар бүслүүрдэж, тугны энгэрт Соёмбо тэмдэгийг
байрлуулсан.

Чингэлтэй дүүргийн “Хүндэт иргэн” одон



Медалийн бэлгэдэл, утга санаа


Чингэлтэй дүүргийн “Хүндэт иргэн” бичэглэл нь үргэлж ялагч, тэргүүлэгч байхын бэлгэдэл Алтанзул цэцгээр хүрээлүүлэн, мандан бадрахын бэлэгдэл нарны дүрсний төв дунд байрлуулав. Дөрвөн зүг найман зовхист гэрэлтэж буй нарны цацраг дээр байрлуулсан товрууг түмэн олон дундаас ажил үйлс, алдар гавъяагаараа тодрон “Чингэлтэй дүүргийн Хүндэт иргэн”-ээр шалгарав гэсэн санааг илэрхийлсэн. Чингэлтэй дүүргээс гаргаж байгаа шагнал учраас логог голд нь оруулж,

бэлгэдэл ногоон өнгийг оруулж өгсөн.


Одонгийн техникийн тодорхойлолт: Медаль нь металлын орцонд хайлш болон хөнгөн цагаан ороогүй 100% цэвэр гуулиар хийгдэнэ. Медалийг 3мм зузаантай металлаар хийх бөгөөд эцсийн бүтээгдэхүүн нь 5-6мм зузаантай бөмбөгөр хэлбэртэй харагдана.

Өндөр: 70мм
Өргөн: 70мм
Зузаан: 5-6мм
Материал: 100% метал

Урдаас



Хажуугаас



Одонгийн өргөмжлөл:


Өргөмжлөл нь 400x280мм хэмжээтэй цаасан дээр хэвлэж нарийн хар өнгийн жаазанд байрлуулна. Өргөмжлөлд байрлах одонгийн дүрсийг алтан клише дарж, деталиудыг гүдгэр хэлбэртэй товойлгон хийнэ.



Одонгийн хайрцаг:

Хайрцаг нь ногоон өнгийн хиймэл арьсан гадартай хатуу хайрцаг байна. Дотор талыг хүрэн улаан хамбаар доторлоно.

Хайрцагны хэмжээ: 210x140мм



ЧАНДМАНЬ ОДОН



Одонгийн бэлгэдэл, утга санаа

Чингэлтэй дүүргийн бэлэгдлийг одонгийн төвд байрлуулан, дүүргийн "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" бичэглэлийг тойруулан оруулав. Дүүргийн

ногоон өнгө бүхий дугуй дүрснээс салаалан цацарч буй нарны цацрагыг Чигэлтэй дүүргийн ажил үйлс мандан бадарч, өргөжин тэлж байхыг бэлэгдэж, дүүргийн бэлгэдэл ногоон өнгө, алтан шар өнгийг хослуулан ашигласан.

Одонгийн техникийн тодорхойлолт: Медаль нь металлын орцонд хайлш болон хөнгөн цагаан ороогүй 100% цэвэр гуулиар хийгдэнэ. Медалиг 3мм зузаантай металлаар хийх бөгөөд эцсийн бүтээгдэхүүн нь 5-6мм зузаантай бөмбөгөр хэлбэртэй харагдана.

Өндөр: 60мм

Өргөн: 53мм

Зузаан: 5-6мм

Материал: 100% металл

Урдаас



Хажуугаас



Одонгийн үнэмлэх: Үнэмлэхний хавтасыг хар ногоон өнгийн хиймэл арьсан материалаар хийж дээрх бичэглэлийг алтан клише дарна. Үнэмлэхний хэмжээ 140x95 мм.



Эрхэм хүндэт

..... таныг
 Дүүргийн хөгжил эрхжилтэнд оруулсан
 хуш нэмэр, хөдөлмөр зүтгэлийг таны үнэлж
 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
 "ЧАНДМАНЬ ОДОН"-оор шагнасан

Дугаар


Чингэлтэй дүүргийн


Дарга

..... Д.Бат-Эрдэнэ

20... оны ... сарын ... өдөр

Одонгийн хайрцаг: Хайрцаг нь ногоон өнгийн хамбан гадар, дотортой хатуу хайрцаг байна. Хайрцагны хэмжээ 100x80x25мм байна.







**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

**Хоршоо хөгжүүлэх дүүргийн дэд
хөтөлбөр батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 173 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 2014-2016 онд хэрэгжүүлэх “Хоршоо хөгжүүлэх дүүргийн дэд хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, жил бүрийн эдийн засаг, нийгмийн зорилт, төсөвт тусган хэрэгжилтийг хангуулж ажиллахыг дүүргийн Засаг /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ





ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР /2013-2017/

Нэг. Нийтлэг үндэслэл

Хөрөнгө, хөдөлмөрөөрөө хоршиж, хамтарч үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нь бүтээмжийг өсгөх, илүү их баялаг бүтээх бололцоо олгож, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хомсдлыг даван туулах болон нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Чингэлтэй дүүрэг нь хүн ам олноор суурьшсан, зах зээлийн багтаамж багатай, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд болон, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид аливаа эдийн засгийн тооцоонд хамрагдахгүй байх тул хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, хоршоодын үйл ажиллагааны давуу талыг ашиглан жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Зорилт

2.1. Чингэлтэй дүүргийн төрийн байгууллагууд болон хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар хоршооны нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг хоршооны хэлбэрээр хөгжүүлэх, ажлын байр бий болгох, нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас, хоршоо жижиг, дунд үйлдвэрлэгч нарт үзүүлж буй үйлчилгээг нээлтэй ил тод шуурхай болгох, оролцох байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхижүүлэх.

2.2.2. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох.

2.2.3. Хоршоог жижиг, дунд үйлдвэрийг дэмжих замаар, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих.

2.2.4. Хоршоо, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн мэдээллийн санг бий болгох, баяжуулах хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээлэлээр хангах, зөвлөгөө өгөх.

Гурав. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Чингэлтэй дүүргийн төрийн байгууллагуудаас, хоршоо жижиг, дунд үйлдвэрлэгч нарт үзүүлж буй үйлчилгээг нээлтэй ил тод шуурхай болгох, оролцох байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхижүүлэх.

3.1.1. Хоршоололын байгууллагуудтай хамтран ажиллаж салбарын хөгжлийн тулгамдсан асуудлыг тодорхойлох, дүүргийн хөгжлийн бодлого стратеги хөтөлбөр боловсруулахад санал авч, хамтран ажиллах.

3.1.2. Газар тариалан, төмс хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг дэмжих;

3.1.3 Дүүргийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг дүгнэхдээ хоршооны хөгжилд оруулсан хувь нэмрийг нэг шалгуур болгох;

3.1.4. Хоршоог хөгжүүлэх чиглэлээр хоршоодын холбоодтой хамтран ажиллах;

3.1.5. Хоршооны удирдлага, боловсон хүчнийг сургах, туршлага солилцох зорилгоор хоршоологчдын чуулганыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

3.1.6. Дүүргийн тэргүүний хоршоо шалгаруулж, урамшуулах.

3.2. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ, үйлчилгээг бий болгох.

3.2.1. Дүүргийн эдийн засгийн тэргүүлэх 4 чиглэл болох оёдол, оёмол бүтээгдэхүүн, сүлжмэл бүтээгдхүүн, модон эдлэл, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгч хоршоог орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг дээрх салбарт чиглүүлж дүүргийн брэнд бүтээгдхүүнийг бий болгоно;

3.2.2. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр төсөл хэрэгжүүлэх;

3.2.3. Дүүрэгт хоршооны нэрийн барааны дэлгүүр ажиллуулах, улирлын чанартай худалдааны лангуу ажиллуулахад нь төрийн дэмжлэг үзүүлэх.

3.2.4. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, туршлага солилцох зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах.

3.3. Хоршоог санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих.

3.3.1. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын эдийн засгийн үр ашиг бүхий төслүүдийг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд хамруулахад дэмжлэг үзүүлэх;

3.3.2. Ажлын байр бий болгож, өрх, бүлэг, нөхөрлөлийн хөдөлмөр эрхлэлтийг хоршооны хэлбэрт шилжүүлэх замаар дүүргийн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа хоршоонд тоног төхөөрөмжийг лизингээр олгох, хөнгөлөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлэх;

3.3.3. Хоршооны салбарт шинэ үйлчилгээ, техник технологи, инноваци нэвтрүүлэх ажлыг сангүүгийн түрээсийн болон зээлийн батлан даалтын санд хамруулах замаар дэмжиж, хөрөнгө оруулалт хийх боломжийг бий болгох.

3.3.4. Хоршоодод түүхий эд, материал, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авахад нь зориулж хөнгөлөлттэй зээлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох;

3.3.5. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр гадаад дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.

3.4. Хоршоо, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн мэдээллийн санг бий болгох, баяжуулах хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт явуулах, мэдээлэлээр хангах, зөвлөгөө өгөх, тогтолцоог бий болгох.

3.4.1 Хоршооны талаарх ойлголт, түүний ач холбогдлыг таниулах анхан шатны сургалт, зөвлөх үйлчилгээ, үзүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах;

3.4.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт хоршоо байгуулах иргэдийг хамруулах;

3.4.3. Дүүргийн хоршоо байгуулах иргэдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд хамруулж үйл ажиллагааг нь өргөжүүлэх;

3.4.4. Мэргэжилтэй, ур чадвар бүхий ажилтан бэлтгэх, дэвшилтэт техник, технологи эзэмших сургалтын тогтолцоог бүрдүүлэх.

3.4.5. Дүүргийн орлого багатай шинээр байгуулагдаж байгаа хоршоод болон нийгмийн эмзэг бүлгийн гишүүдээс бүрдсэн хоршоог бие дааж ажиллах чадвартай болгон бойжуулах төрөлжсөн инкубаци үйлчилгээг Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн газар, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөрийн хэлтэс, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв, Хоршоо дэмжих төвүүдтэй хамтран зохион байгуулах;

3.4.6. Хөрөнгө, хөдөлмөрөөрөө хоршин амжилттай ажиллаж байгаа дүүргийн хоршоологчдын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хоршоологчдын захиалгаар хоршооны сургалтыг жишиг хоршоо дээр сонгон явуулах;

3.4.7. Хоршоо хөгжүүлэх чиглэлээр олон улсын сургалт, семинар, зөвлөгөөнийг хоршоодын байгууллагуудтай хамтран зохион байгуулах, хоршоодын хөгжлийн хүрээнд гадаад харилцааг өргөжүүлж, боловсон хүчин, мэргэжилтнийг олон улсын түвшинд мэргэшүүлэн бэлтгэж дүүргийн хоршоодыг хамруулах

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөрийн хэлтэс хамтран хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүүргийн хэмжээнд зохицуулах хяналт тавих үүргийг хөдөлмөр эрхлэлтийн салбар Зөвлөл хариуцан ажиллана.

4.3. Дүүргийн зөвлөлийн дарга нь Чингэлтэй дүүргийн /Засаг даргын орлогч/ байх бөгөөд салбар зөвлөлийн бүрэлдхүүнийг батална.

4.4. Дүүргийн салбар зөвлөлийг /Засаг даргын орлогч/ тэргүүлж, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж гаргана. Зөвлөлийн бүрэлдэхүүнд дүүргийн захиргаа, дүүргийн хоршоодын холбоо болон хоршооллын хөдөлгөөнийг дэмжигч байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.5. Дүүргийн салбар зөвлөлийн үүрэг

4.5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр зохион байгуулах;

4.5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах явцад хяналт тавих;

4.5.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэн дүгнэж, хагас болон бүтэн жилээр салбар зөвлөлд тайлагнаж байх;

4.5.4. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төсөл, хөтөлбөр, бичил бизнесийг дэмжих чиглэлээрх төрийн болон төрийн бус байгууллагуудыг хоршооны хөдөлгөөнийг дэмжихэд оролцуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

5.1.1. Дүүргийн төсөвт тусгах;

5.1.2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

5.1.3. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төслийн хөрөнгө;

5.1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

5.1.5. Бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлсэн үр дүн

6.1. Хөтөлбөр хэрэгжүүлснээр үр дүнг дараах үзүүлэлтээр тооцно.

6.1.1. Хоршооллын салбарын нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ;

6.1.2. Ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурч, хоршооны гишүүдийн орлого, амьдралын чанар дээшилнэ;

6.1.3. Хоршооны хөгжлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжсэнээр хоршоо болон гишүүдийн тоо өсч, хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ өснө;

6.1.4. Тоног төхөөрөмж олж авах, хөнгөлөлттэй зээл, лизингийн үйлчилгээ болон зээлийн баталгаанд хамрагдах, ажил, үйлчилгээ эрхлэх байртай болох зэрэг иргэд дангаараа эрхлэх боломжгүй ажил, үйлчилгээг хамтран гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ;

6.1.5.Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын сүлжээг бий болгосноор хоршоодын борлуулалтын орлого, цэвэр ашиг, гишүүдэд хуваарилсан ногдол ашиг нэмэгдэнэ;

6.1.6.Хоршоодын, сургалт, сурталчилгаа өргөжүүлж, хоршоог дэмжигч байгууллага, хоршооны үүрэг, ач холбогдлын талаарх ойлголт нийгэмд бий болно.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

7.1. Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

7.1.1. Хоршоо болон түүний гишүүдийн тоо, тэдгээрийн үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт;

7.1.2. Хоршооны удирдлага, гишүүдэд зориулсан сургалт, зөвлөгөө, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, чанар тэдгээрийн үр дүн, төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны өсөлт;

7.1.3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олгосон ЖДҮХС болон ХЭДС-гийн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн түрээсийн /лизинг/ үйлчилгээнд хамрагдсан хоршоо, түүний гишүүдийн тоо болон гадаадын зээл, тусламжийн өсөлт, түүний үр дүн, шинээр бий болгосон ажлын байрны тоо.